

2021 он, III улирал



ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН САР ТУТМЫН МЭДЭЭЛЭЛ

2021 ОНЫ III улирлын мэдээ



Арвайхээр хот

2021 он

2021 он, III улирал

Энэхүү товхимолын дэлгэрэнгүй мэдээллийг www.ov.mohs.gov.mn цахим хуудаснаас татаж харна уу.

Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсээс эрхлэн гаргав. E-mail: <http://www.ov.mohs.gov.mn/>, uvurkhangaiemg@gmail.com

Утас: 7032-2195, 99668055

Хянан тохиолдуулсан:

Я. Жаргал

Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга


Эмхэтгэсэн:

Д. Нацагням

Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Статистикч их эмч


1. Эх, хүүхдийн эрүүл мэнд

График 1.1. Төрсөн эх, насны бүлгээр, тохиолдлын тоогоор /2021 оны III улирал/




Аймгийн хэмжээнд 2021 оны эхний III улирлын байдлаар 1660 эх төрснөөс 5,7 хувь нь 10-19 насандаа, 76,3 хувь нь 20-34 насандаа, 14,9 хувь нь 35-39 насандаа, 3,1 хувь нь 40-өөс дээш насандаа төрсөн байна.

График 1.2. Төрсөн эх, насны бүлгээр, төрөлтөнд эзлэх хувиар, 2021 оны III улирал




2021 он, III улирал

График 1.3. Төрсөн эх, жирэмслэлт, төрөлтийн байдал




Аймгийн хэмжээнд 2021 оны эхний III улирлын байдлаар 1660 эх төрснөөс 24,6 хувь нь анхны төрөлт, 25,9 хувь нь 2 дах төрөлт, 25,3 хувь нь 3 дах төрөлт, 16,7 хувь нь 4 дах төрөлт, 7,5 хувь нь 5 болон түүнээс дээш удаагийн төрөлт байна.

График 1.4. Төрөлт, эмнэлгийн төрлөөр, 2021 оны III улирал




Аймгийн хэмжээнд 2021 оны эхний III улирлын байдлаар төрсөн эхийн 75,7 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 15,4 хувь нь Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт, 8,9 хувь нь сум, сум дундын эмнэлэгт төрсөн байна.

График 1.5. Жирэмсний хяналтын үед үзүүлсэн тоо, 2020, 2021 оны III улирал




2021 оны эхний III улиралд нийт төрсөн эхчүүдийн дийлэнх хувь нь 5-7 удаа үзлэгт хамрагдсан байна. Төрсөн эхчүүдийн 25.9 хувь нь 6 удаа, 20.1 хувь нь 7 удаагийн жирэмсний үзлэг, хяналтанд хамрагдсан байна.

График 1. 6. Касер хагалгаагаар төрсөн эх, насны бүлгээр, 2021 оны III улирал



2021 оны эхний III улирлын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүд 441 буюу нийт төрөлтийн 26.6 хувийг эзэлж байгаа ба үүнээс 2 хувийг 15-19 нас, 18 хувийг 20-24 нас, 23 хувийг 25-29 нас, 31 хувийг 30-34 нас, 21 хувийг 35-39 нас, 5 хувийг 40-44 нас, 1 хувийг 45-аас дээш насныхны төрөлт тус тус эзэлж байна.

График 1. 7. Төрөлтийн хүндрэл, насны бүлгээр, 2020, 2021 оны III улирал



2021 оны эхний III улирлын байдлаар мэс заслын аргаар төрсөн эхчүүдийн 32.0 хувь нь жирэмсний хүндрэлтэй, 6.3 хувь нь төрөлтийн хүндрэлтэй, 1.4 хувь нь төрөлтийн дараах

2021 он, III улирал

үеийн хүндрэлтэй төрсөн байна. 2021 оны III улиралд бүртгэгдсэн төрөлтийн хүндрэлийн 35 хувийг 20-24 насны төрөлт, 25 хувийг 25-29 насны төрөлт, 19 хувийг 30-34 насны төрөлт, 12 хувийг 35-39 насны төрөлт, 6 хувийг 15-19 насны охидын төрөлт, 3 хувийг 40-өөс дээш насны эмэгтэйчүүдийн төрөлт тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчин

График2. 1. Халдварт бус өвчлөл, тохиолдлын тоогоор, 2019-2021 оны III улирал





График2. 2. Халдварт бус өвчний үзлэг, тасгийн төрлөөр, эзлэх хувиар, 2021 оны III улирал




Аймгийн хэмжээнд 2021 оны эхний III улирлын байдлаар халдварт бус өвчний нийт 32551 өвчлөл бүртгэгдсэн ба тасгийн төрлөөр авч үзвэл дотрын тасгаар үйлчлүүлсэн иргэд 15.9 хувийг, хүүхдийн тасгаар үйлчлүүлсэн хүүхэд 9.2 хувийг, эх барих, эмэгтэйчүүдийн тасгаар үйлчлүүлсэн эмэгтэйчүүд 7.7 хувийг, нүд, чих, хамар хоолойн тасгаар үйлчлүүлсэн иргэд 7.4 хувийг тус тус эзэлж эдгээр тасгуудад ачаалал их байна.

График2. 3. Халдварт бус өвчлөл, өвчний төрлөөр, тохиолдлын тоогоор, 2021 оны III улирал



Аймгийн хэмжээнд 2021 оны эхний III улирлын байдлаар халдварт бус өвчний нийт 32551 өвчлөл бүртгэгдсэнээс хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл 24 хувийг, шээс бэлгийн тогтолцооны өвчлөл 15 хувийг, зүрх судас, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны өвчлөл 14,9 хувийг, Нүд, чих, хөхлөг сэртэнгийн өвчлөл 10,2 хувийг, амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл 10,1 хувийг тус тус эзэлж өвчлөлийг тэргүүлж байна.

График2. 4. Эрэгтэйчүүдийн халдварт бус өвчлөл, тохиолдлын тоогоор, 2020-2021 оны III улирал



2021 оны III улирлын байдлаар 32551 халдварт бус өвчлөл бүртгэгдснээс 35.7 хувийг эрэгтэйчүүдийн өвчлөл, 64.3 хувийг эмэгтэйчүүдийн өвчлөл эзэлж байна. Халдварт бус өвчлөл 10000 хүн амд 2812.5 ноогдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 12194 тохиолдлоор буюу 1023.5 пунктээр буурсан байна. Халдварт бус өвчлөлд хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, зүрх, судасны эрхтэн тогтолцоо, амьсгалын замын эрхтэн тогтолцооний өвчлөл тэргүүлж байна.

График2. 5.Эмэгтэйчүүдийн халдварт бус өвчлөл, тохиолдлын тоогоор, 2020-2021 оны III улирал






График2. 6. Хоол боловсруулах тогтолцоо (K00-K92), тухайн насны 1 000 хүн амд, 2020-2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл 55-74 насны 1 000 хүн амд 105.5 ногдож тухайн насны хүн амд өвчлөлийн тархалт их байгаа бол 18-34 насны 1000 хүн амд 49.0 ногдож өвчлөлийн тархалт тухайн насны хүн амд бага үзүүлэлттэй байна.

График2. 7. Шээс бэлгийн тогтолцоо (N00-N99), тухайн насны 1 000 хүн амд, 2020-2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар шээс, бэлгийн эрхтэн тогтолцооны өвчлөл 18-34 насны 1 000 хүн амд 62.4 ногдож тухайн насны хүн амд өвчлөлийн тархалт их байгаа бол 0-5 насны 1000 хүүхдэд 6.0 ногдож өвчлөлийн тархалт бага түвшинд байна.

График2. 8 Зүрх, судасны тогтолцоо (I00-I99), тухайн насны 1 000 хүн амд, 2020-2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар зүрх судас, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны өвчлөл 75-аас дээш насны 1 000 хүн амд 215.4 ногдож тухайн насны хүн амд өвчлөлийн тархалт их байгаа бол 0-5 насны 1000 хүүхдэд 0.3 ногдож өвчлөлийн тархалт бага түвшинд байна.

График2. 9. Амьсгалын тогтолцоо (J00-J98), тухайн насны 1 000 хүн амд, 2020-2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар амьсгалын замын эрхтэн тогтолцооны өвчлөл 0-5 насны 1 000 хүүхдэд 78.7 ногдож тухайн насны хүн амд өвчлөлийн тархалт их байгаа хэдий ч өмнөх оны мөн үеэс 2.7 дахин буурсан байна. 18-34 насны 1 000 хүн амд 0.3 ногдож өвчлөлийн тархалт бага түвшинд байна.

График2. 10. Нүд, чих, хөхлөг сэртэнгийн өвчлөл (H00-H93), тухайн насны 1 000 хүн амд, 2020-2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар нүд чих, хөхлөг, сэртэнгийн өвчлөл 75-аас дээш насны 1 000 хүн амд 60.1 ногдож тухайн насны хүн амд өвчлөлийн тархалт их байгаа ба өмнөх оны мөн үеэс 30.5 пунктээр буурсан байна. 18-34 насны 1 000 хүн амд 16.4 ногдож өвчлөлийн тархалт бага түвшинд байна.

График2. 11. Арьсны эмгэг (L00-L98), тухайн насны 1 000 хүн амд, 2020-2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар арьс, арьсан доорх эслэгийн өвчлөл 0-5 насны 1 000 хүүхдэд 26.3 ногдож тухайн насны хүн амд өвчлөлийн тархалт их байгаа ба өмнөх оны мөн үеэс 23.9 пунктээр буурсан байна. 35-54 насны 1 000 хүн амд 13.5 ногдож өвчлөлийн тархалт бага түвшинд байна.

График2. 12. 0-17 насны хүүхдийн халдварт бус өвчлөл, өвчний төрлөөр, 2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар 0-17 насны хүүхдийн дунд 32 хувийг хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл, 25 хувийг амьсгалын замын эрхтэн тогтолцооний өвчлөл, 12 хувийг арьсны эмгэг эзэлж хүүхдийн өвчлөлийн дийлэнхи хувийг эзэлж байна.

График2. 13. 75-аас дээш насныхны өвчлөл, өвчний төрлөөр, 2020оны III улирал



2021 он, III улирал


График2. 14. 75-аас дээш насныхны өвчлөл, авчний төрлөөр, 2021 оны III улирал



2021 оны III улирлын байдлаар 75-аас дээш насны хүн амын өвчлөлийн дунд 42,1 хувийг зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл, 15,2 хувийг хоол боловсруулах эртэн тогтолцооны өвчлөл, 11.7 хувийг нүд, чих хөхлөг сэртэнгийн өвчлөл эзэлж ахмад настнуудын өвчлөлийн дийлэнхи хувийг эзэлж байна.


Коронавирус(COVID-19)-т халдвар

График3. 1. Коронавируст халдвар(COVID-19) өвчлөл, 10 000 хүн амд, 2021 оны эхний III улиралд




2021 оны эхний 9 сарын байдлаар Шинэ Коронавируст халдварын 9066 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 783.3 ноогдож байгаа нь улсын дунджаас 147.5 пунктээр бага үзүүлэлттэй байна.

График3. 2. Коронавируст халдвар(COVID-19) өвчлөл, нас , хүйсээр, 1 000 хүн амд, 2021 оны III байдлаар




Коронавируст халдварын өвчлөл 75 аас дээш насныханд хамгийн өндөр тархалттай буюу 75-аас дээш насны 1000 эрэгтэйд 139.9, 75-аас дээш насны 1000 эмэгтэйд 122,9 ногдож байгаа бол 0-17 насны хүүхдэд тархалтын түвшин бага үзүүлэлттэй байна.

График3. 3. Коронавируст халдвар(COVID-19) авсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид, /2021 оны 09 сарын байдлаар/



2021 оны эхний III улирлын байдлаар Коронавирус(COVID-19)-ын халдвараар нийт 382 эмч, эмнэлгийн мэргэжилтэн өвчилсөн бөгөөд нийт өвчлөлийн 4.2 хувийг эзэлж байна.


График3. 4. Коронавируст халдварын шалтгаант нас баралт, сараар, 2021оны III улирал



2021 он, III улирал

2021 оны 5-9 дүгээр саруудад Коронавируст халдварын шалтгаант 35 нас баралт бүртгэгдснээс 18 тохиолдол 51 хувь нь 9 дүгээр сард нас барсан байна.


График3. 5. Коронавируст халдварын шалтгаант нас баралт, нас, хүйсээр, тохиолдлын тоогоор, 2021 оны III улирал



Коронавируст халдварын шалтгаант нас баралтын 35 тохиолдол бүртгэгдснээс 5.7 хувь нь 0-5 насанд, 11.4 хувь нь 35-54 насанд, 37.1 хувь нь 55-74 насанд, 45.7 хувь нь 75-аас дээш насанд бүртгэгдсэн байна.

Нас баралт


График4. 1. Нас баралт, нас, хүйсээр, 1000 хүн амд, 2021 оны III улиралд



2021 оны III улирлын байдлаар аймгийн хэмжээнд нас баралтын 451 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 78 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нийт нас баралтын 265 тохиолдол буюу 58.8 хувь нь эрэгтэй, 186 буюу 41.2 хувь нь эмэгтэй байна. Нас баралтын түвшин 75-аас дээш насны 1 000 хүн амд хамгийн өндөр буюу тухайн насны 1 000 хүн амд 65.7 ногдож өмнөх оны мөн үеэс 29.7 пунктээр буурсан байна.

2021 он, III улирал


График 4. 2. Нас баралтын шалтгаан, төрлөөр, 2020, 2021 оны III улирал



2021 оны III улирлын байдлаар 451 нас баралт бүртгэгдсэнээс 46.6 хувийг зүрх судас, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны шалтгаант нас баралт, 22.1 хувийг хорт хавдрын шалтгаант нас баралт эзэлж нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байна.




График4. 3. Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, тухайн нас, хүйсний 10 000 хүн амд, 2021 оны III улирал




2021 оны III улирлын байдлаар осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 47 тохиолдол бүртгэгдснээс 85.1 хувийг эрэгтэй, 14.9 хувийг эмэгтэйчүүдийн нас баралт эзэлж байна. 75-аас дээш насныхны дунд уналтын шалтгаант нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

График4. 4. Осол гэмтлийн шалтгаант нас баралт, хүйсээр, тохиолдлын тоогоор, 2019-2021 оны III улирал



Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 2021 оны III улиралд 47 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор өссөн бол, 2019 оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.


График4. 5. Зүрх судас, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны шалтгаант нас баралт, нас, хүйсээр /1000 хүн амд/, 2021 оны III улирал



2021 он, III улирал

2021 оны III улирлын байдлаар зүрх судас, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны шалтгаант нас баралт 75-аас дээш насны 1 000 эрэгтэйд 534.4, 75-аас дээш насны 1 000 эмэгтэйд 285.9 ногдож байна. 75-аас дээш насны 1000 хүн амд ногдох эрэгтэйд ногдох нас баралт эмэгтэйчүүдийн нас баралтаас 248,5 пунктээр их байна.

График4. 6. Хорт хавдрын шалтгаант нас баралт, нас, хүйсээр /1000 хүн амд/, 2021 оны III улирал



2021 оны III улирлын байдлаар хорт хавдрын шалтгаант нас баралт 75-аас дээш насны 1000 эрэгтэйд 139.9, 75-аас дээш насны 1 000 эмэгтэйд 177.7 ногдож байна. 75-аас дээш насны 1000 хүн амд ногдох эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийн нас баралтаас 38.4 пунктээр бага байна.